



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/447

Мандалговь

**Аймгийн “Шилдэг төрийн албан хаагч”
шалгаруулж, урамшуулах тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, аймгийн Засаг даргын 2017 оны А/407 дугаар захирамжаар батлагдсан “Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж, урамшуулах журам”-ын 6.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

Нэг. Аймгийн “Шилдэг төрийн албан хаагч”-аар 1 дүгээр хавсралтад дурьдсан 9 төрийн албан хаагчийг шалгаруулж, тус бүр цом, 1000000 (нэг сая) төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шилдэг төрийн албан хаагчийн шагнал, урамшууллын зардлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Гурав. Шагнал, урамшууллын зардалд шаардагдах 9.450.000 (есөн сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191262

Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 23-ны өдрийн 447 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

“ШИЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ”-ААР
ШАЛГАРСАН АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Албан тушаал	Шагналын нэр
1	Мөнхбаярын Адъяабаатар	Онцгой байдлын газрын дарга	Шилдэг менежер
2	Сумъяадоржийн Цэнгэлмаа	Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн	Захиргаа, хууль эрх зүйн салбарын Шилдэг төрийн албан хаагч
3	Доржхандын Батзаяа	Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 25 дугаар ангийн аврагч-гал сөнөөгч	Захиргаа, хууль эрх зүйн салбарын Шилдэг төрийн албан хаагч
4	Төмөрхүүгийн Мөнхцэцэг	Өндөршил сумын Соёлын төвийн эрхлэгч	Соёл, урлагийн салбарын Шилдэг төрийн албан хаагч
5	Өлзийжаргалийн Ууганбаяр	Аймгийн Төв номын сангийн сүлжээний инженер, бичиг хэргийн ажилтан	Соёл, урлагийн салбарын Шилдэг төрийн албан хаагч
6	Цэрэнгийн Отгончулуун	Биеийн тамир, спортын газрын дасгалжуулагч	Биеийн тамир, спортын салбарын Шилдэг төрийн албан хаагч
7	Адъяагийн Алтанчимэг	Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн ахлах эх баригч	Эрүүл мэндийн салбарын Шилдэг төрийн албан хаагч
8	Даваагийн Долгорсүрэн	Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгийн арга зүйч сувилагч	Эрүүл мэндийн салбарын Шилдэг төрийн албан хаагч
9	Жалбуугийн Батбилэг	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржилийн албаны дарга бөгөөд аймгийн ерөнхий мал зүйч	Хөдөө аж ахуйн салбарын Шилдэг төрийн албан хаагч

Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 23-ны өдрийн 417 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



“ШИЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ”-ИЙН УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Урамшуулал	9	1000000	9 000 000
2	Цом	9	45000	405 000
3	Батламж	9	5000	45 000
	ДҮН			9 450 000